

“ЗАВХАНБАЯЛАГ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026-03-20

Дугаар 02

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай

Компанийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1, 60.2, 60.4 дэх хэсэг, 62 дугаар зүйлийн 62.1.7, 62.1.9, 62.1.13, 62.1.15 дахь заалт, 76 дугаар зүйлийн 76.1.2, 76.1.3 дахь заалт, мөн Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 377 дугаар тогтоолыг тус тус үндэслэн “Завхан баялаг” хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс ТОГТООХ нь:

1. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2026 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 14:00 цагт Улиастай хот дахь компанийн төв байранд танхимаар болон цахим хэлбэрээр хуралдуулахаар тогтоосугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлуудыг хэлэлцүүлэхээр тогтоосугай. Үүнд:
 - 2.1. Компанийн Гүйцэтгэх Удирдлагаас 2025 онд хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан болон 2026 оны төлөвлөгөө;
 - 2.2. Компаний 2025 оны санхүүгийн тайлан түүнд хийсэн хараат бус Аудитын дүгнэлтийг батлах;
 - 2.3. ТУЗ болон Гүйцэтгэх удирдлагын төсвийг батлах;
 - 2.4. Ноогдол ашиг хувиарлах эсэх талаар гарсан ТУЗ-аас гаргасан шийдвэрийг батлах;
 - 2.5. ТУЗ-ын гишүүдийг шинээр сонгох.
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2026 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр байхаар тогтоосугай.
4. 2026 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдэд хурлын зарыг 2026 оны 03 дугаар сарын 25-ны өдрөөс эхлэн өдөр тутмын сонин, компанийн болон Монголын хөрөнгийн бирж ХК-ийн цахим хуудас болон бусад мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлэх, мөн 2026 оны 04 дүгээр сарын 09-ний өдөр анх нийтэд мэдээлсэн хэлбэрээр хэвлэл мэдээллийн хэрэгслээр давтан мэдээллэхийг хурал зохион байгуулах комисст даалгасугай.
5. 2026 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэгийг 1 дүгээр хавсралтаар, танилцах баримт бичгийн жагсаалтыг 2 дугаар хавсралтаар, санал авах хуудсыг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай. Эдгээр баримт бичигтэй хувьцаа эзэмшигчдийг 2026 оны 03 дугаар сарын 30-ны өдрөөс эхлэн ажлын өдрүүдэд 10:00–17:00 цагийн хооронд “Завхан баялаг” хувьцаат компанийн төв байранд болон цахим хэлбэрээр танилцах боломжоор хангаж ажиллахыг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга /Б.Түмэндэмбэрэл/-д даалгасугай.
6. Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдээс санал авах “Саналын хуудас”-ны агуулгыг 3 дугаар хавсралтаар баталсугай.

7. Хувьцаа эзэмшигчдээс "Саналын хуудас"-ыг харьяалах үнэт цаасны компаниар нь дамжуулан хүлээн авах сүүлийн хугацааг 2026 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 17:00 цаг байхаар тогтоосугай.
8. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг удирдах хурлын даргаар Ю.Бат-Эрдэнийг томилсугай.
9. Хурлын тооллогын комиссын даргаар Л.Аззаяаг, гишүүдээр Д.Нарантуяа, Ц.Оюунчимэг нарыг тус тус томилсугай.
10. Хурал зохион байгуулах комиссын даргаар Н.Ариунзаяаг, гишүүдээр Б.Түмэндэмбэрэл, Я.Ганбаатар нарыг тус тус томилсугай.
11. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зохион байгуулах бэлтгэлийг хангаж ажиллахыг хурал зохион байгуулах комисс (Н.Ариунзаяа)-д үүрэг болгосугай.
12. Хуралд оруулах асуудлыг боловсруулах, хурлын зар болон холбогдох материалыг брокерийн компаниуд болон Монголын хөрөнгийн биржид хүргүүлэх, хувьцаа эзэмшигчдэд мэдээллийг тухай бүр хүргэх, хурлын бэлтгэл ажлыг хугацаанд нь бүрэн хангаж ажиллахыг Гүйцэтгэх захирал Ю.Бат-Эрдэнэ болон хурал зохион байгуулах комисс (Н.Ариунзаяа)-д тус тус даалгасугай.

ТУЗ-ын дарга



Я.Өлзийбүрэн

УЛАХАН АЙМАГ
ийн 02 дугаар хурлын
тоолын 1-р хавсралт
ХХ
2010.08.08-н 2011.07.13

1.	Хурлын ирцийг бүртгэх (Тооллогын комисс)	13:50-14:00
2.	Хурлын ирцийг мэдээлэх (Тооллогын комисс)	5 минут
3.	Хурлын дарга хурлыг нээж, хурлын дэгийг танилцуулах	10 минут
4.	Хурлаар хэлэлцэх асуудлыг танилцуулж, хэлэлцүүлэх	60 минут
4.1.	Компанийн ТУЗ-өөс 2025 онд хийсэн ажлын тайлан, 2026 онд хийх ажлын тухай	
4.2.	Компанийн 2025 оны санхүүгийн тайлан түүнд хийсэн хараат бус Аудитын дүгнэлтийг батлах	
4.3.	ТУЗ болон Гүйцэтгэх удирдлагын төсвийг батлах	
4.4.	Ноогдол ашиг хувиарлах эсэх талаар гарсан ТУЗ-ын шийдвэрийг батлах	
4.5.	ТУЗ-ын гишүүдийг шинээр сонгох	
5.	Асуулт хариулт, санал	30 минут
6.	Санал хураалт	5 минут
7.	Хурлын завсарлага, тооллогын комисс санал хураалтын дүнг гаргах	15 минут
8.	Тооллогын комиссын тогтоолыг танилцуулах	10 минут
9.	Хурлаас гарах шийдвэр, тогтоолыг танилцуулах	10 минут
10.	Хурлыг хаах (Хурлын дарга)	5 минут

ТУЗ-ийн 2026 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн 02 дугаар хурлын
1 дүгээр тогтоолын 2-р хавсралт



**“ЗАВХАН БАЯЛАГ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН
ТАНИЛЦУУЛАХ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ**

1. Компаний Гүйцэтгэх удирдлагаас 2025 онд хийсэн ажлын тайлан, 2026 онд хийх ажлын төлөвлөгөөний тухай.
2. Компаний 2025 оны санхүүгийн тайлан түүнд хийсэн хараат бус Аудитын дүгнэлт.
3. ТУЗ болон Гүйцэтгэх удирдлагын Төсөв.
4. Ноогдол ашиг хувиарлах эсэх талаар гарсан ТУЗ-ын шийдвэрийг батлах.
5. ТУЗ-ын гишүүдийг шинээр сонгох.

ТУЗ-ийн 2026 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн 02 дугаар хурлын
1 дүгээр тогтоолын 3-р хавсралт

**"ЗАВХАНБАЯЛАГ" ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН 2026 ОНЫ ЭЭЛЖИТ
ХУРЛЫН САНАЛ АВАХ ХУУДАС**

Хувьцаа эзэмшигч /эсхүл төлөөлөх этгээд/ овогтой

Регистрийн дугаар

Гэрийн хаяг

Эзэмшиж буй хувьцааны тоо

Төлөөлж байгаа бол хэнийг, эсхүл ямар хуулийн этгээдийг төлөөлж буй хэн болох тухай тайлбар

Төлөөлж буй хүний нэр, регистр

Хурлаас гаргах шийдвэр	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн
1.Компаний ТУЗ-өөс 2025 онд хийсэн ажлын тайлан, 2026 онд хийх ажлыг батлах.			
2. Компаний 2025 оны санхүүгийн тайлан түүнд хийсэн Аудитын дүгнэлт.			
3.ТУЗ болон Гүйцэтгэх удирдлагын төсвийг батлах.			
4. Ноогдол ашиг хувиарлах эсэх талаар гарсан ТУЗ-ын шийдвэрийг батлах			
5.Компанийн ТУЗ-ийн гишүүдийг 2 жилийн хугацаатай сонгох.			
ТУЗ-ЫН ГИШҮҮНД			
1.Я.Өлзийбүрэн.			
2. Я.Ганбаатар			
3.Г.Түвшинбат.			
4. Ю.Бат-Эрдэнэ.			
5.М.Алтанцэцэг.			
6.Т.Мөнхбаатар.			
ТУЗ-ЫН ХАРАА БУС ГИШҮҮНД			
7. Ц.Чанцаа.			
8. Я.Хишигдэлгэр			
9. П.Баянмөнх.			

Хувьцаа эзэмшигчийн гарын үсэг..... /

Санал авах хуудсыг хүчингүйдтооцсон бол шалтгаан.....

Саналын хуудсыг хүчинтэйд тооцон тоолсон

Тооллогын комиссын дарга..... /Н.Ариунзаяа /

Гишүүн..... /Д.Аззаяа /

..... /Д.Нарантуяа/